Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 8 дугаар зүйлд дараах хэсгийг нэмсүгэй:

“8.3.Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт заасан журмыг батална.”

**2 дугаар зүйл.** Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.3.Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахтай холбоотой харилцааг журмаар зохицуулна.”

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг ..... оны .....дугаар сарын .....ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт “Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглахтай холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан тусгай журмаар зохицуулж болно.” гэж заасан.

Ингэснээр авто зам, төмөр замын салбарт Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлж буй зарим төсөл, хөтөлбөрүүдэд шаардагдах элс, хайрга, барилгын материалыг төсөл гүйцэтгэгч нарт богино хугацаанд түргэн шуурхай нийлүүлэх боломжийг бүрдүүлсэн байдаг.

Сүүлийн жилүүдэд уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөгжлийн чиг хандлагатай уялдан уул уурхайн бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр өсөж буйтай холбоотой уул уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх тусгай зориулалтын авто замын бүтээн байгуулалтын ажил нэмэгдэж, түүнд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалын эрэлт, хэрэгцээ өссөөр байна. Энэхүү өсөн нэмэгдэж буй эрэлт, хэрэгцээг богино хугацаанд найдвартай эх үүсвэрээс хангах шаардлага гарч байна.

Дээрх шаардлагыг хангах үүднээс Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийг **“Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахтай холбоотой харилцааг журмаар зохицуулна.”** гэж өөрчлөхөөр хуулийн төсөлд тусгасан бөгөөд журам батлах эрхийг Засгийн газарт олгосон нэмэлт зохицуулалтыг мөн хуулийн төсөлд тусгалаа.

Хуулийн төсөл батлагдснаар шинээр захиргааны хэм хэмжээний акт гаргахгүй бөгөөд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Засгийн газрын 2025 оны 82 дугаар тогтоолоор баталсан журмыг шинэчлэн найруулах тул Хууль тогтоомжийн тухай хуулийн $27^1$ дүгээр зүйлийн $27^1$.3 дахь хэсэгт заасан захиргааны хэм хэмжээний акт гаргах хугацаа болон хуулийг дагаж журмын тухай хуулийн төслийг боловсруулаагүй болно.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу боловсруулагдан Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх тусгай зориулалтын авто замыг барихад шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах зөвшөөрөл олгох үйл ажиллагаа хялбар түргэн шуурхай болох бөгөөд улмаар материалын зардал, хугацааг бууруулж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлнэ.

Улмаар уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нэмэгдэж, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх тул Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоог хийлээ.

## АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ